



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 756

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Дээд шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,560,000.00 /нэг сая таван зуун жаран мянга/ төгрөгийн хөрөнгийг хавсралтад заасны дагуу Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга О.Солонго нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
 756 дугаар тогтоолын хавсралт

Улсын Дээд шүүхийн тамгын газрын данснаас хасч Баянгол, Хан-Уул Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газарт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Ширээ	1/1/2004	1	100,000.00
2	Ширээ	1/1/2004	1	100,000.00
3	Шүүгчийн ширээ	1/1/2004	1	300,000.00
4	Шүүгчийн ширээ	1/1/2004	1	500,000.00
5	Сандал	1/1/2004	1	10,000.00
6	Сандал	1/1/2004	1	10,000.00
7	Сандал	1/1/2004	1	10,000.00
8	Сандал	1/1/2004	1	10,000.00
9	Сандал	1/1/2004	1	10,000.00
10	Сандал	1/1/2004	1	10,000.00
11	Шүүгчийн сандал	1/1/2004	1	100,000.00
12	Шүүгчийн сандал	1/1/2004	1	100,000.00
13	Шүүгчийн сандал	1/1/2004	1	100,000.00
14	Шүүгчийн сандал	1/1/2004	1	100,000.00
15	Шүүгчийн сандал	1/1/2004	1	100,000.00
				1,560,000.00
				/нэг сая таван зуун жаран мянга/
	Нийт дүн			